

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН ДАДЛАГА СУРГУУЛИЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ДХИС-ийн магистрант, ахмад Х.Цэнд-Очир

Хураангуй: Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндэс нь дадлага, сургуулилт байдаг. Гал түймэр унтраах аврах, анги гал түймэр унтраах өдөр тутмын, тархалт, тактикийн дадлага сургуулийг хийдэг. Дадлага, сургалтыг зохион байгуулснаар бие бүрэлдэхүүнийг сэтгэл зүй, ур чадвар, бие бялдрын хувьд бэлтгэн дадлагажуулах, багаар ажиллах ажиллагаа, харилцан ойлгох, өндөр ачаалалтай ажиллах, гал түймэр унтраах, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах чадварыг эзэмшдэг. Энэхүү өгүүлэл нь гал түймэр унтраах, аврах ангийн дадлага сургуулилын талаарх бодлого, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, судалгааны талаар өгүүлэв.

Түлхүүр үгс: Гал түймэр унтраах дасгал сургуулилт

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурлаар гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос 2030 он хүртэл хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичиг батлагдсан.

Тус бодлогын баримт бичигт “Гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах” 4 үндсэн чиглэлийг тусгасан билээ.

Дээрх дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцүүлэн Монгол улсын Засгийн газраас Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газрын (2021-2024) онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү төлөвлөгөөнд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх”⁶¹ зорилтын хүрээнд Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх⁶², гал түймэр унтраах, эрэн хайх, аврах ажиллагааны хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлнэ⁶³ хэмээн төлөвлөн алслагдсан суурин газруудад гал түймэр унтраах, аврах нэгжийг шинээр байгуулж, Япон, Австри, Хятад, Польш, Беларусь, Франц зэрэг улсуудтай Засгийн газар хоорондын зээл, тусламж, төсөл хөтөлбөрөөр гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашинууд гал түймэр унтраах, аврах ангиудад нийлүүлэн

⁶¹ Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичиг

⁶² Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1

⁶³ Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4

автомашины тоо 302 болж хангалт 63 хувьд хүргэн⁶⁴ гал түймэртэй тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Иймд гал түймэр унтраах, аврах ангийн дадлага сургуулилтын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

ҮНДСЭН ХЭСЭГ

Онцгой байдлын байгууллага нь Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнгийг сургаж дадлагажуулахад чиглэнэ⁶⁵ хэмээн заасны дагуу дараах ангилалаар сургалт зохион байгуулж байна. Үүнд:

- Удирдах албан тушаалтны
- Онцгой байдлын байгууллагын
- Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалт, ажилтны
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн
- Иргэний сургалт гэсэн ангиллаар зохион байгуулж байна.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, бие бялдар сэтгэл зүйн бэлтгэлийг хангах сургалтыг жил бүр сургуулийн жилийн удирдамж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ажлын байранд нь зохион байгуулдаг⁶⁶.

Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл” гэж Онцгой байдлын байгууллагад хуулиар хүлээсэн “Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх” үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг хангахад чиглэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зорилго, чиглэл бүхий цогц үйл ажиллагааг хэлдэг⁶⁷.

Онцгой байдлын албаны сургалтын бодлого, хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөө, сургалт бэлтгэлийг зохион байгуулах журам, сургалт бэлтгэлийг шалгаж, үнэлэх журмыг 2020 онд Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/308 дугаар тушаалаар батлан үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байгаа билээ.

Тус сургалтын бодлогын баримт бичгийн хүрээнд Онцгой байдлын албаны сургалт нь:

- Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт,
- Алба хаагчдыг мэргэшүүлэх болон албан тушаалтны давтан сургалт,
- **Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт** гэсэн тогтолцооноос бүрдэнэ хэмээн заасан байна.

⁶⁴ Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө (2021-2024)

⁶⁵ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.1

⁶⁶ Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, (Монгол Улсын Шадар сайдын тушаал №67)

⁶⁷ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/308 тушаар тушаал, гуравдугаар хавсралт 1.2

Харин Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн эрдэмтэн, багш, судлаач нарын эрхлэн гаргасан гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага номонд бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалтын дараах төрлүүдийг тодорхойлсон⁶⁸. Үүнд:

- Анхан шатны тусгай сургалтын бэлтгэл
- Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүний бэлтгэл (өдөр тутмын, тархалт, тактикийн)
- Дадлага сургалт
- Дунд болон ахлах дарга нарын албаны бэлтгэл
- Мэргэжил дээшлүүлэх
- Давтан бэлтгэх
- Бие даан бэлтгэх гэсэн сургалтын төрлүүдийг тодорхойлсоноос үзэхэд Онцгой байдлын албаны сургалтын бодлогыг боловсруулахдаа гал түймэр унтраах аврах ангийн томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүний бэлтгэлжилт, сургалт, дадлага сургуулилтын талаар орхигдуулсаныг харуулж байна.

Сургалтын жилийн хөтөлбөр, төлөвлөгөөнд цагийн ачааллын 40 хүртэл хувийг онолоор, 60 хүртэл хувийг дадлагаар офицер, ахлагч, үйлчилгээний ажилчид гэсэн төрлөөр 7 хоногийн нэг өдрөөр бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн зохион байгуулан хэмээн заасан байдаг.

Бие бүрэлдэхүүний хичээлийн хөтөлбөрийн цаг, сэдвийн төлөвлөгөөнд офицер, ахлагч бүрэлдэхүүн, төрөл мэргэжлийн аврагч нарын мэргэжлийн бэлтгэл, эрэн хайх, аврах анги, агаарын салбар, уул уурхайн аврах анги, улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн салбарын сургалт бэлтгэлийн хөтөлбөр, тусгай бэлтгэлд ангил хэл, жагсаалын бэлтгэл, бие бялдар, сэтгэл зүй, эрүүл мэнд, эрэн хайх, аврах нохойн сургалтуудыг баталсан боловч гал түймэр унтраах, аврах ангийн сургалт, дадлага сургуулилт /өдөр тутмын, тархалт, тактикийн, амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах/, гал түймэр унтраах дасгал сургуулилтын нормативын талаар тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хэмжээнд Гал түймэр унтраах, аврах анги 69, гэрээт гал түймэр унтраах 1 анги, нийт 70 гал түймэр унтраах, аврах анги үйл ажиллагаа явуулж байна. Дээрх гал түймэр унтраах, аврах ангиудын бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндэс нь дадлага, сургуулилт байдаг. Дадлага, сургалтыг зохион байгуулснаар бие бүрэлдэхүүнийг сэтгэл зүй, ур чадвар, бие бялдрын хувьд бэлтгэн дадлагажуулах, багаар ажиллах ажиллагаа, харилцан ойлгох, өндөр ачаалалтай ажиллах, гал түймэр унтраах, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах чадварыг эзэмшдэг чухал ач холбогдолтой. Иймд Онцгой байдлын албаны сургалтын тогтолцоонд гал түймэр унтраах, аврах ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүний сургалтыг нэмэлтээр оруулж, гал түймэр унтраах дасгал сургуулилтын нормативыг тусгай бэлтгэлжилтийн хөтөлбөрт тусгах шаардлага байна.

Ашигласан материал

1. Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичиг

⁶⁸ Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага УБ 2021 214 х

2. Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1
3. Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4
4. Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө (2021-2024)
5. Гамшгаас хамгаалах тухай хууль
6. Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, (Монгол Улсын Шадар сайдын тушаал №67)
7. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/308 тушаар тушаал, гуравдугаар хавсралт 1.2
8. Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага УБ 2021